



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймаг дахь Шүүхийн тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/199/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayaq@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.17 № 1302/52

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ДОРЖДЭРЭМ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Audit(D)A4-гэрчилгээ/2022/

013022922

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Д.Бат-Ундраа* Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,608.90</u>	<u>7,250.50</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	7,608.90	7,250.50
354	Хангамжийн материал	7,608.90	7,250.50
35410	Бичиг хэргийн материал	1,610.40	1,467.50
35420	Аж ахуйн материал	5,998.50	5,783.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>403,747.60</u>	<u>477,479.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	403,747.60	477,479.89
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	381,684.27	455,616.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	423,635.80	423,635.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-94,418.91	-141,628.37
39203	Авто-тээврийн хэрэгсэл	101,710.00	163,710.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-101,710.00	-106,015.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,738.70	271,774.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-173,211.29	-180,569.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,460.44	62,460.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,811.27	-38,320.64
39217	Ном	290.80	570.04
393	Биет бус хөрөнгө	22,063.33	21,863.33
39301	Програм хангамж	1,000.00	1,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-66.66	-266.66
39303	Бусад биет бус хөрөнгө	21,130.00	21,130.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>411,356.50</u>	<u>484,730.39</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>411,356.50</u>	<u>484,730.39</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	411,356.50	484,730.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	305,363.82	305,363.82
51101	Өмч: - төрийн	305,363.82	305,363.82
512	Хуримтлагдсан үр дүн	-366,115.17	-292,741.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-366,115.17	-366,115.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	73,373.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	472,107.86	472,107.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>411,356.50</u>	<u>484,730.39</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,098,872.08	1,220,240.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,127.68	123,870.92
120	Нийтлэг татварын бус орлого	21,127.68	81,722.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,176.44	81,256.83
122	Тусламжийн орлого	00.00	42,147.99
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	42,147.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,077,744.40	1,096,369.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,077,744.40	1,093,369.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,077,744.40	1,093,369.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,139,363.55	1,146,866.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,139,363.55	1,146,866.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,115,557.84	1,143,884.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	791,284.69	813,215.52
210101	Үндсэн цалин	625,143.79	569,113.41
210102	Нэмэгдэл	126,238.30	197,827.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,531.50	24,278.17
210104	Урамшуулал	14,371.10	21,996.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,019.20	107,741.60
210201	Тэтгэврийн даатгал	75,497.80	75,491.19
210202	Тэтгэмжийн даатгал	7,880.30	8,072.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,304.30	6,447.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,576.10	1,611.53
210205	Эрүүл мэндийн даатгал	15,760.70	16,118.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,186.21	51,151.67
210301	Гэрэл, цахилгаан	5,332.10	4,366.79
210302	Түлш, халаалт	43,329.44	43,528.44
210303	Цэвэр, бохир ус	3,524.67	3,256.44
2104	Хангамж, бараа материалын зардал	66,982.24	48,672.92
210401	Бичиг хэрэг	19,102.44	11,014.98
210402	Тээвэр, шатахуун	28,237.10	18,087.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,945.50	7,995.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,480.00	1,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,217.20	10,095.25

2105	Нормативт зардал	800.00	800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800.00	800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,077.34	38,360.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,788.80	6,742.60
210604	Урсгал засвар	12,288.54	31,617.70
2107	Томилолт, зочны зардал	11,218.20	14,312.90
210702	Дотоод албан томилолт	11,218.20	14,312.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,696.90	9,047.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,682.60	3,682.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	564.00	558.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,135.50	4,135.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223.80	217.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66.00	06.00
210807	Газрын төлбөр	25.00	388.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,293.06	60,582.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,293.06	60,582.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,805.70	2,981.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,948.44	2,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,948.45	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000.00	2,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,857.25	981.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,857.25	981.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-40,491.47</u>	<u>73,373.88</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-40,491.47</u>	<u>73,373.88</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	305,363.82	472,107.86	-325,623.70	00.00	451,847.98
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	305,363.82	472,107.86	-325,623.70	00.00	451,847.98
С06	Орлогын тайланд хүлээн	00.00	00.00	-40,491.47	00.00	-40,491.47

	зөвшөөрөөгүй олз, гарз					
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	305,363.82	472,107.86	-366,115.17	00.00	411,356.50
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	305,363.82	472,107.86	-366,115.17	00.00	411,356.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	305,363.82	472,107.86	-366,115.17	00.00	411,356.50
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	73,373.88	00.00	73,373.88
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	305,363.82	472,107.86	-292,741.28	00.00	484,730.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,077,744.40</u>	<u>1,096,369.50</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,077,744.40	1,096,369.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,077,744.40	1,093,369.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,077,744.40	1,093,369.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,075,533.20</u>	<u>1,085,459.50</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,075,533.20	1,085,459.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,051,727.49	1,082,477.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	791,284.69	813,215.52
210101	Үндсэн цалин	625,143.79	569,113.41
210102	Нэмэгдэл	126,238.30	197,827.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,531.50	24,278.20
210104	Урамшуулал	14,371.10	21,996.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,009.60	107,741.60
210201	Тэтгэврийн даатгал	75,488.20	75,491.19

210202	Тэтгэмжийн даатгал	7,880.30	8,072.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,304.30	6,447.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,576.10	1,611.53
210205	Эрүүл мэндийн даатгал	15,760.70	16,118.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,186.21	51,151.67
210301	Гэрэл, цахилгаан	5,332.10	4,366.79
210302	Түлш, халаалт	43,329.44	43,528.44
210303	Цэвэр, бохир ус	3,524.67	3,256.44
2104	Хангамж, бараа материалын зардал	64,743.10	48,118.73
210401	Бичиг хэрэг	16,863.30	10,405.99
210402	Тээвэр, шатахуун	28,237.10	18,087.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,945.50	7,995.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,480.00	1,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,217.20	10,150.05
2105	Нормативт зардал	800.00	800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800.00	800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,788.79	38,090.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,788.80	7,090.00
210604	Урсгал засвар	12,999.99	31,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,218.20	14,312.90
210702	Дотоод албан томилолт	11,218.20	14,312.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,696.90	9,047.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,682.60	3,682.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	564.00	558.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,135.50	4,135.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223.80	217.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66.00	66.00
210807	Газрын төлбөр	25.00	388.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,805.70	2,981.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,948.45	2,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,948.45	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000.00	2,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,857.25	981.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,857.25	981.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,211.20</u>	<u>10,910.00</u>

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,211.20	10,910.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,211.20	10,910.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,211.20	10,910.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,211.20	10,910.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,211.20	-10,910.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,093,369.50	1,092,387.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,369.50	1,092,387.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,091,369.50	1,090,387.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	813,284.70	8,132,155.23
210101	Үндсэн цалин	647,143.80	569,113.41
210102	Нэмэгдэл	126,238.30	197,827.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,531.50	24,278.17
210104	Урамшуулал	14,371.10	21,996.16
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,634.60	107,741.60
210201	Тэтгэврийн даатгал	77,113.20	75,491.19
210202	Тэтгэмжийн даатгал	7,880.30	8,072.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,304.30	6,447.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,576.10	1,611.53
210205	Эрүүл мэндийн даатгал	15,760.70	16,118.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,152.50	51,151.67
210301	Гэрэл, цахилгаан	4,556.10	4,366.79
210302	Түлш, халаалт	43,329.40	43,528.44
210303	Цэвэр, бохир ус	3,267.00	3,256.44
2104	Хангамж, бараа материалын зардал	45,118.80	45,118.73
210401	Бичиг хэрэг	10,406.00	10,405.99

210402	Тээвэр, шатахуун	18,087.00	18,087.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,995.80	7,995.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,480.00	1,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,150.00	7,150.05
2105	Нормативт зардал	800.00	800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800.00	800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,000.00	49,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000.00	18,000.00
210604	Урсгал засвар	31,000.00	31,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,318.90	14,312.90
210702	Дотоод албан томилолт	14,318.90	14,312.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,060.00	9,047.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,682.60	3,682.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	564.00	558.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,135.50	4,135.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223.80	217.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66.00	66.00
210807	Газрын төлбөр	388.10	388.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000.00	2000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.00	2,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.00	2,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,093,369.50	1,093,369.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,093,369.50	1,093,369.50
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,093,369.50	1,093,369.50
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	05.00	04.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	23.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан-оруулах

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймаг дахь шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай байна гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1,220,240.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,303.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,727.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	0	0
Бараа материал	7,608.9	7,250.5	358.4
Үндсэн хөрөнгө	403,747.6	477,479.9	73,732.3
Нийт хөрөнгө	411,356.5	484,730.9	74,090.4
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	411,356.5	484,730.9	74,090.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	411,356.5	484,730.9	74,090.4

Бараа материалын дансны үлдэгдэл 358.4 мянган төгрөгөөр буурсан нь аудитын залруулгатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 73,732.3 мянган төгрөгөөр өссөн нь 62,000.0 мянган төгрөгөөр шинээр автомашин, 20,476.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн Шүүхийн ерөнхий газраас нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 74,090.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,093,369.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,092,387.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,092,387.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,092,006.4 төгрөгийг зарцуулж, 981.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар Нийгмийн даатгалын сангаас листний 2,355.2 мянган төгрөг, Аймгийн ИТХ-аас ГХУСАЗСЗ-ын үйл ажиллагааны зардалд зориулж 2000.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын 2021 оны А/503 захирамжийн дагуу 1000.0 мянган төгрөгийг олгож зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ямар нэгэн зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын төсвийн зардлын зарцуулалтыг хянахад албан томилолтоор ажилласан албан хаагчид албан томилолтын хуудсанд очсон, ирсэн хугацааг бичүүлээгүй, очсон газрын баталгаажуулсан хугацаагаар бус томилсон хоногоор томилолт тооцож олгосон дутагдал илэрснийг залруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар залруулсан, акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй болно.